

**ПРОФЕССОР ПОППЕГИЙН “ХАЛХ МОНГОЛ ХЭЛНИЙ ХЭЛЗҮЙ” НОМЫН
ТУХАЙ ПРОФЕССОР ШИРО ХАТТОРИГИЙН ТЭМДЭГЛЭЛ**

Л. Энхсайхан*

Профессор Поппегийн бичсэн (*Professor Nikolaus Poppe*) *Khalkha-Mongolische Grammatik, mit Bibliographie, Sprachproben und Glosser. Akademie der Wissenschaften und der Literatur: Veröffentlichungen der Orientalischen Kommission, Band I. Wiesbaden: Franz Steiner Verlag GMBH. 1951, pp XII+188.* энэ номд шүүмж бичээч гэж редакцын газраас би захиалга хүлээн авсан юм. Монгол хэлний халх аялгуу нь журамлагдсан, утга зохиолын хэлний нөлөө ихтэй аялгуу тул эртнээс миний судлахыг хүсч байсан зүйл бөгөөд 1951 оны 6-р сард Америкийн Калифорни муж улсын Барклийн (*Berkeley*) Калифорни их сургуульд ажиллаж байхад, гудамжинд монгол хувцас өмсөж, тайван алхаж яваа өвгөн ламтай тааралдан, цэрвэлгүй яриа өрнүүлж, сайхан халх аялгуугаар тов тодорхой хариулах үед хацарт нь улаа бутарч байсныг санаж байна. Энэ өвгөн лам чухамхүү гадаад монголын Улиастай орчмын Нарванчин хийдийн Дилав багш байсан юм. Би энэ өвгөн ламын халх хэлэнд сэтгэл татагдан, тэр жилийнхээ 8-р сард Мичиганы их сургуулиас явсны дараа Харвардын их сургууль болон бусад газар судалгааны ажил хийх бодлоо орхин, Балтиморын Жонс Хопкинсын их сургуульд ажиллах болсон юм.

Тэгээд тус сургуулиас тэтгэлэг авч байсан өвгөн багшийн тухай болон хагас жил гаруй хугацаанд түүний хэлийг судлах болсон юм. Багшийн хэл аялгуу нь тодорхой хэлбэл Улаанбаатарын аялгуунаас нэлээд зөрүүтэй байсан боловч халх аялгууны тухай олон жил дотроо тээж явсан эргэлзээтэй олон асуудлын учгыг тайлж чадсан боловч цаг хугацаа дэндүү хурдан өнгөрсөнд харамсаж байлаа. Шёовагийн 10-р он буюу 1935 онд Манжуурын Хөлөнбуйрын Шинэ барга хошууны Амгалан хашаатад сууж байхдаа тус хошууны Зүүн өмнөд суманд халх аялгуугаар ярих тус нутгийн сургуулийн хэдэн сурагчийн хэлийг судалж байсан юм. Гэвч ямар ч байсан залуучуудын хэл яриа, их боловсролтой өвгөн ламын хэл ярианаас илэрхий зөрүүтэй байсан юм. Ийнхүү давчуу цаг хугацаанд хүсэл маань биелж багшийн хэл яриаг судалсан шалтгааныг ч гэсэн ойлгох байх. Багшийн аялгууг цэвэр хүрээ аялгуу гэж хэлж чадахгүй байлаа. Ялангуяа, миний бие нэгэнт одоогийн Улаанбаатарын аялгууны тухайд түүний суурь болсон ном зохиол, хэл судлаачдын тэмдэглэлийг судлах л боломж байгаа тул өнөө хүртэлх судалгаанд шүүмжлэлтэй хандах зүйл нэлээд байгаа мэт бодогдоно. Тэгэхдээ зөвхөн цуглуулсан хэрэглэгдэхүүнээ нэгтгэн дүгнэж хэвлүүлэх нь огт утгагүй зүйл биш гэдэгт итгэж байна. Ядаж Поппе профессорын шинэ бүтээлийг танилцуулах завшааныг ашиглан өөрийнхөө санаа бодлыг дурдах нь тохиромжтой биш болов уу гэж бодож байгаа ч ажлын байдлаас болж энэ удаа маш товчхон санаанд орсон хэдэн зүйлийн тухай дурдахаас өөр цаг боломж хомс байна.

* МУИС-ийн МХСС-ийн багш (*Япон хэлнээс орчуулав*)

Нөгөө талаар америкт амьдарч, англи, францад очиж байхад би боломжийн хирээр олон эрдэмтэдтэй уулздаг байлаа. Тэр уулзалт маань маш богино хугацаанд болдог байсан ч гэлээ тэдгээр эрдэмтдийн өгүүлэл, бүтээлийг мэдэж ойлгоход тус дөхөм болдог байв. Америкт байхдаа би азаар Поппе профессортой хоёр удаа уулзах завшаан тохиосон билээ. Анхны уулзалт маань 1950 оны 8-р сарын сүүлчээр зуны амралтаараа Вашингтоноос Кэмбрижид очиж номын сан болон их сургуультай танилцаж явахдаа уулзсан юм. Вашингтонд ирмэгц хотын гадна орших Мостарт багшийн гэрт зочилж, Поппе профессорыг Вашингтонд байгааг мэдсэн. Багшид даруй захидал явуулсан тул, нэгэн орой профессор хэрэг болгон манай байранд ирсэн билээ. Олон жилийн турш зөвхөн ном зохиол, өгүүллээр нь дамжуулан мэдэж байсан шилдэг эрдэмтэн, энэ насандаа уулзаж чадахгүй байхаа гэж бодож байсан тэр хүн миний өмнө байж надтай ярилцаж байна гэдгийг би ахин дахин эргэцүүлэн бодож, хүний гайхалтай хувь заяандаа сэтгэл хөдлөхгүй байж чадсангүй. Тэр үеийн ярианы эхний нэг цаг нь монгол хэлээр, дараагийн гурван цаг нь орос хэлээр болсныг тэмдэглэн авсан нь дэмий зүйл байгаагүй болов уу. Хоёрдахь уулзалт маань 1951 оны 6-р сард болсон бөгөөд дээр дурдсан Барклид болсон юм. Дилав багш нэгд, монгол заншлыг дагаж зуны улирлыг сэрүүн газар өнгөрөөхөөр, хоёрт, хэдийнээ тэтгэвэртээ гарч Калифорнийн их сургуулиас явсан Лейссинг профессорын (*Professor Ferdinand D. Lessing*) эмхэтгэж байгаа Монгол-Англи толь бичгийн ажилд туслахаар тус хотод нүүж ирсэн байлаа. Лейссинг профессортой уулзах үед Поппе профессор мэдээж энэхүү ажилд зөвлөгөө өгөхөөр ойрын өдрүүдэд Барклид ирнэ гэдгийг дуулж мэдсэн юм. Иймд би явах хугацаагаа боломжийн хирээр сунгаж, профессортой уулзахаар болсон. Энэ боломжийг ашиглан уулзсан анхны уулзалтад маань Дилав багш, Лейссинг профессорын туслах Касаткин нөхөр, Поппе профессор бид дөрвүүлээ байлаа. Энэ уулзалт их сонирхолтой байсныг уншигч та бүхэн лав төсөөлж байгаа байх. Үүний дараа ч гэсэн би профессортой хоёулхнаа хэдэн цаг хөөрөлдсөн юм. Энэхүү уулзалтаар олж авсан мэдлэг, сэтгэгдэл маань миний, профессорын өгүүлэл, бүтээлийг ойлгоход ихээхэн тус дэм болсон мэт бодном.

Ингээд оршил маань нэлээд нуршиж байгаа тул Поппе профессорын дээр дурдсан бүтээл нь халх монгол аялгууны хамгийн шилдэг хэлний зүйн нэг гэдэгтэй маргахгүй юм. Профессорын 1931 онд хэвлүүлсэн *“Практический учебник монгольского разговорного языка (Халхаское наречие) Ленинград, 1931.”* гэдэг бүтээлтэй харьцуулахад нэмж засварласан газар цөөнгүй байх бөгөөд дээрх ном ховордсон тэр цаг үед шинээр хэвлэгдэн гарсан юм. Үүний дээр орос хэлээс герман хэл илүүтэй япончуудын хувьд ойр дөт учраас талархууштай. Чухамхүү монгол хэл судлаач мэргэлжилтнүүд ховор уул хэлний тухайд хэл шинжлэлийн үүднээс үзвэл маш бүрхэг боловч анхан шатны сурах бичиг, хэлний зүйн бичгүүд нэг бус удаа хэвлэгдсэн байдаг. *“Монгол хэлний сайн гарын авлага байдаг уу”* гэсэн асуултад хариулахад хүндрэлтэй байдаг байлаа. Нэгд, монгол хэлийг, нэг үгээр хэлбэл монгол үсгээр тэмдэглэсэн бичгийн хэл, ярианы хэл тун зөрүүтэй, бичгийн хэлний тухайд толь бичиг болон хэлний зүйн бичгүүд мэр сэр байдаг болохоор бичгийн хэлээр монгол хэл сурах хүн олон байдаг боловч монгол үсэг нь монгол хэлний авиалбарыг бүрэн гүйцэд төлөөлж чаддаггүй, бичгийн хэл нь олон түвшинд ярианы хэлний нөлөө ихтэй тул монгол бичгийн хэлний судалгаагаар монгол хэлний хэлний бүтцийг тодорхой зөв ойлгоход туйлын бэрх байлаа. Ямар ч байсан аман ярианы хэл судалсны дараагаар түүнтэй харьцуулан бичгийн хэл судлах нь зүйтэй гэсэн тайлбар хүчтэй байв. Ярианы хэлний

тухайд Рамстед профессорын “Халимаг хэлний толь”, Мостарт багшийн “Ордос толь” Поппе профессорын “Буриаг хэлний зүй” зэрэг бүтээлүүд байх бөгөөд журамламал халх аялгууны хувьд эдгээртэй тэнцэх томоохон толь бичиг болон нэгтгэсэн хэлний зүй байхгүй байна. Байдал ийм үед хамгийн найдвартай монгол хэл судлаач эрдэмтний нэг болох Поппе профессор нь халх аялгууны системчилсэн хэлний зүйг герман хэлээр олны хүртээл болгосон нь яг эрдэм шинжилгээний эрэлт шаардлагад нийцсэн бүтээл боллоо гэдгийг хэлэх хэрэгтэй юм. Номын төгсгөлд үлгэр болон дууны бичвэр (27-н нүүр), түүнийг уншихын тулд хэрэглэх үгийн сан (24-н нүүр), хэлний зүйн бүтээвэрийн хэлбэрүүд, нэр томьёоны хэлхээг (12 нүүр) хавсаргасан учраас эхлэн суралцагчид түүнийг бие даан сурснаар ярианы бичвэрийг уншиж чаддаг болох юм. Мөн 12 нүүр бүхий ном зүйн гарчиг оруулж өгсөн нь монгол хэлийг гүнзгийрүүлэн судлах хүмүүс ашиглахад тохирсон гарын авлага болжээ. Миний бие цаашид дээрхтэй адил асуултад хариулах болбол ямар ч тээнэгэлзэх зүйлгүй энэхүү номыг санал болгоно.

Тус номын агуулга нь:

<i>Удиртгал (Einleitung)</i>	1~11-р нүүр
<i>Авиа зүй (Lautlehre)</i>	12~13-р нүүр
<i>Үг бүтэх ёс (Wortbildungslehre)</i>	31~52-р нүүр
<i>Бүтээвэр зүй (Eormenlehre)</i>	53~97-р нүүр
<i>Өгүүлбэр зүй (Satzlehre)</i>	98~113-р нүүр

“Удиртгал” бүлэгт Халх монгол хэл (*Би дээр монгол хэлний халх аялгуу гэж хэлсэн*) болон бусад олон монгол хэлний тухай дурдаж, монгол хэлний түүхийг тоймлон, монгол үсэг болон монгол бичгийн хэлний түүхийг тайлбарлаж, халх монгол хэл, монгол бичгийн хэлний харилцааг товч дурджээ. Тэрхүү тайлбартай санал зөрөх зүйл огт байхгүй гэж хэлж чадахгүй боловч, бүхэлд нь авч, үзвэл сайн нэгтгэж дүгнэсэн, тайлбар сайтай болжээ. Үүнд олон аялгууг тайлбарласан товч тайлбарыг жишээ болгон авбал, (3-р нүүр)

Bargu(tšibtšin)im Bargu-Gebiet der Mandschurei und verschiedene kleine Mundarten, welche mangelhaft erfoscht sind.

гэсэн зүйл байх бөгөөд, Манжуурын барга нутаг, өөрөөр хэлбэл Хөлөнбуйрын барга аялгуугаар ярих монгол хошууг

Шинэ барга зүүн хошуу	10386 хүн
Шинэ барга баруун хошуу	5677 хүн
Хуучин барга хошуу	5314 хүн

гурван хошуунд хувааж (1934 он) Зүүн шинэ барга хошууны зүүн өмнөд хэсэг халх язгуурын аялгууг эс тооцвол зүүн баруун, шинэ барга хошууны ихэнх нь ярих “Шинэ барга аялгуу” нь халх аялгуунаас нэлээд зөрүүтэй байх бөгөөд Хуучин барга хошууны гол аялгуу болох “Хуучин барга аялгуу” нь ч гэсэн ялгагдах онцлог бүхий аялгуу юм. (Монгол судлал, 『蒙古学』 1-р ботид гарсан өгүүллийг харах) Чибчин гэдэг нь Хуучин барга аялгуугаар ярилцагчдыг өөр бусад монголчууд нь ихэрхэж нэрлэсэн нэр бөгөөд барга хүмүүс бол чибчин хүмүүс биш юм. Цахар хүмүүс өөрсдийгөө “*džaxAr*” гэж нэрлэж, Цицигарын дагуурууд өөрсдийгөө (*daur*) гэж нэрлэдэг байна.

Авиан зүйн хэсэгт (*Ерөнхий хэсэг, өргөлт, эгшиг авиа, хос эгшиг, эгшиг зохицох ёс, гийгүүлэгч авиа*) зэрэг олон зүйлээс бүрдэж байна. Ерөнхийдөө тэмдэглэсэн зүйлүүд нь нарийн тодорхой зөв, системтэй болсон байна. Ялангуяа анхаарал татсан зүйл бол[]дотор хийсэн нарийвчилсан галигаас гадна товчилсон галигийг нэмж оруулсан байх бөгөөд сүүлийнх нь авианы галигт ихэд ойртсон байна. Гэвч ярианы галигийн

элементүүд байсаар байгаа нь харамсалтай юм.. Жишээ нь: профессорын товчилсон галигаар *dz, dʒ, ts, tʃ*-ээр илрэх хамжин шүргэх авиа, аль аль нь дан авиалбартай тохирно гэж бодож байгаа учраас авианы галигаар тус тус *z, ʒ, c, ʃ*-тэй адил нэг нэг үсгээр тэмдэглэх ёстой юм. Хэрэв эдгээр хамжин шүргэх гийгүүлэгч нь хамжих гийгүүлэгч, шүргэх гийгүүлэгчийн нэгдлээс бүтэх авиалбартай тохирно гэж тайлбарлавал, халх монгол хэл нь зөвхөн энэ тохиолдолд үеийн эхний хоёр гийгүүлэгч авиалбарын нэгдэл (*бусад тохиолдолд нэг гийгүүлэгч авиалбар*) болох төдийгүй, */dz, dʒ/* авиалбарын дотор */d/* авиалбар дангаар илрэх боловч */z/* болон */ʒ/* нь дангаараа илрэхгүй тул тохирохгүй болно.

Мөн профессор */sara/ cap, /gar/гар* –ыг ингэж ялган бичсэн байх агаад минийхээр бол эдгээр нь хам цагийн онолоор */sara, gara/* гэж галиглах ёстой, ялангуяа хоёулаа авианы хоёр үеэс бүтэж, үеүд нь задгай үеэ CV гэсэн бүтэцтэй гэж тайлбарлах ёстой гэж бодогдоно. (*Цуваа цагийн онолоор /gara/ нь /gar /-аас үүсэлтэй гэж хэлж болно.*) Гэвч эдгээр үг нь хэлбэрийн хувьд ялгагдах үүрэгтэй байх тохиолдол байна. Жишээ нь: */tai/* -тай гэдэг бүтээвэр залгахад */xaratai, gartai/* болно. (*Энэ нь өвөрмонголын цахар аялгуунд ч мөн адил байна. Мостарт багшийнхаар бол Ордосын аялгуунд хара, гар нь ялгаатай бөгөөд буриад аялгуунд ч гэсэн мөн адил ялгаа байна. Дээрх нь Дулав багшийн дуудлага, кирилл үсгийн зөв бичгийн дүрмээс үзэхэд тэгж таамаглаж болно.*)

Нэгдүгээр үед */a, o, u/* гэсэн эгшиг авиалбартай эр үгийн тухайд 2-р үеийн */ra/ /ri/* нь ялгаатай бөгөөд (жишээ нь: */bara/, /bari/* гэдэг нь авиалбар зүйн хувьд хэлбэр нь ялгаатай байна), Профессор нь 1-р үед *д ц ь* орсон эм үгийн 2-р үед ч гэсэн */rd/* болон */ri/* ялангуяа (*профессорын re болон ri*) ялгааг хүлээн зөвшөөрч байна. “Дундад үеийн монгол хэл”-д энэхүү ялгаа байсан бол орчин цагийн халх монгол хэлэнд ч байгаа болов уу хэмээн бодож байна. Эм үгийн хувьд гийгүүлэгч нь бага зэрэг зөөлөрч тагнайшдаг тул суларсан 2-р үед */rd/, /ri/*-ийг ялгах нь дуудлагын хувьд хүндрэлтэй байдаг. Профессор тус номын 15-р нүүрнээ:

Дараах үеийн суларсан *e, ē* өөрөөр хэлбэл суларсан *i*-ийн өмнө энэ эгшиг (*e*) нь хэт урагшилж, хэт давчуу *e* авиа болж байна. Нарийвчилсан галигаар *é*-ээр тэмдэглэнэ. Жишээ нь: *tere (t'èrə)* тэр, *ene (ènə)* энэ болох бөгөөд миний бодлоор (ялангуяа 1-р үед) илрэх богино эгшиг нь урт эгшиг *ē*-ээс илүү урагшилж, бага зэрэг давчуу байгаа нь түүний дараа орох гийгүүлэгч нь зөөлөрч тагнайших тул түүний нөлөө байж болно гэж бодном. Мэдээж авиалбар зүйн хувьд */d, dd/* гэж тайлбарлах ёстой тул энэ богино эгшигт зориулан тусгай эгшиг авиалбар бий болгох ёсгүй юм. Профессорын товчилсон галигаар бол *e, ē* гэж тэмдэглэсэн нь зөв юм. Мөн *ai* болон *ä* нь авиалбарын үүднээс хоёулаа */ai/* болох болов уу гэж бодож байна. Үг бүтэх ёсны тухайд (*нэр үг, тэмдэг нэр, тооны нэр, дайвар үг, үйл үг*)-ийн тухай бичсэн байна. Үгийн үндэс бүтээх олон залгаврын утга нь бодит жишээний хамт дурдагдсан байх агаад номын эцэст товъёг оруулж өгсөн тул уншигчдад ихээхэн дөхөмтэй болсон болов уу. Миний хүсэж байсан зүйл бол хам цагийн үүднээс идэвхтэй (*productive*) болон идэвхгүй (*non-productive*) гэж ялгаж өгсөн бол сайн байх байж. Жишээ нь 35-р талд *-lga-* дагаврын утгыг тухайн үйлийн объект, өөрөөр хэлбэл явц гэж дурджээ.

uṣilga *uṣi*
xālga *xā* гэсэн жишээ авчээ.

Гэвч дээрх *uṣi* болон *uṣilga* нь *xā* болон *xālga*-аас ялгаатай. (*хуйх*) гэдэг утгатай дагавар *lga* (*~lge*)-нь ихэнхдээ ямар ч үйл үгийн үндсэнд залгаж болдог бол *xālga* нь бага зэрэг хуучирсан хэлбэр тул, дээрх *uṣilga* болон *xālga*-ыг адил жишээ гэж

үзэж болохгүй юм. Хам цагийн үүднээс авч үзвэл дээрх зүйлийг анзаарахгүй өнгөрч боломгүй байлаа.

Олон хэлбэрт олон дагавар залгаж бүтэх нэр ба үйл үгийн үндэс нь тэдгээрийг залгаж болохгүй цэвэр үгийн үндэстэй бараг адил үүрэгтэй байдаг бол (*тооны нэр*)-ийн олон хэлбэрүүд нь олон хэлбэрт дагавар залгаж бүтсэн (*тооны нэр*) гэж нэрлэх тодорхой үүрэг бүхий хэлбэр биш бөгөөд (*тооны нэрийн үндсэнд*) олон дагавар залгаж бүтсэн олон үүрэг бүхий хэлбэр юм. Иймд тэдгээр олон хэлбэрийн үүргийг дурдсан бол сайн байжээ. Жишээ нь: *gurwadagār* нь нэр үгтэй холбогдож түүнийг тодотгож өгдөг бол *gurwūlā* нь үйл үгтэй холбогдон гурвуулаа, хамт гэх утгыг илэрхийлнэ. *gurwadagār* гэхэд тийм үүрэг байхгүй байна. 43-р нүүрийн 69-р зүйлд хэмжээ илэрхийлэх хэлбэрийн үүрэг ч мөн тодорхой биш байна.

Бүтээвэр зүй нь (*олон тоо, биеийн хамаатуулах дагавар, нэр үгийн хувилал, төлөөний нэр, дагавар үг, үйл үгийн хувилал, заах үйл үйл үг, асуух үйл үг, туслах үг, асуух үг, холбоос үг, аялга үг*) зэргээс бүрдэж, 45 нүүрийг хамарсан, тус номын цөм хэсэг болсон юм. Маш нарийн тодорхой бичсэн байх тул уншигчдад ойлгомжтой болсон байна. Миний бичихээр төлөвлөж байсан товчоолох арга нь профессорынхоос нэлээд зөрүүтэй тул нэг бүрийн тухай дурдахад нэлээд урт болох юм. Ерөнхийд нь хэлбэл бүтээврийн утга миний хэрэглэсэн нэр томьёо (*意義素*) (*утга*) -ийн товчоолох аргаас нэлээд ялгаатай бөгөөд үүний талаар японы хэл шинжлэлийн нийгэмлэгийн хэвлэл “*Хэл судлал*” 22/ 23 дугаарт миний бичсэн өгүүлэл “*Утгын тухай ажиглалт*” 371-р нүүрийг үзээрэй. Тэнд миний арга зүйн үндсэн онолыг товчхон дурдсаны зэрэгцээ халх монгол хэлний өгүүлбэрийг төгсгөх үйл үгийн хувиллын хэлбэр (*нөхцөл*) “*утга*”-ын тухай Поппе профессорын бичсэнтэй харьцуулж дурдсан юм. Энд цөөн хэдэн зүйлийн тухай өөрийн саналыг хэлье.

Нэр үгийн хувиллын хэлбэр болгон профессорын авсан жишээ 9 тийн ялгалын дотор хамгийн сүүлийн *Höhenkasus* (*өндрийн хэмжээ заасан тийн ялгал*) нь (*120 -р зүйл*) дараах 2 зүйлд бусад хувиллын хэлбэрээс ялгаатай байна. Нэгд, энд маргаантай байгаа хамаатуулахын хэлбэр *-tsē* нь цөөн тооны нэр үгэнд л залгаж, нэр үг болгонд чөлөөтэй залгаж болохгүй. Хоёрт, түүнийг залгасан хэлбэр нь “*тэмдэг нэр*”-тэй адил үүрэгтэй байна. Иймд энэхүү хамаатуулах хэлбэр нь хувилах нөхцөл гэхээс илүү тэмдэг нэрийн үндэс бүтээх дагавар гэж үзэх ёстой гэж бодож байна. Гэвч проф. Поппе хамтрахын тийн ялгал (*Komitativ*)-ын (*119-р зүйл*) нөхцөл гэж үзсэн *-tai-* г үүргийн хувьд *-tsē*-тэй адил биш үү гэж үздэг хүмүүс ч байдаг. Хэрвээ тэгж үзэж байгаа бол миний хувьд энэхүү хамаатуулах хэлбэрийг ч гэсэн тэмдэг нэрийн үндэс бүтээх дагавар гэж үзэх ёстой биш үү гэж бодном. Мөн профессор 37-р талд нэрээс үүссэн тэмдэг нэр (*Denominale Adjektiva*)-ийг бүтээх дагавар болгож авсан *-tai*-тай адил хэлбэр гэж үзсэн байна. *-tai* залгасан “*хамтрахын тийн ялгалын хэлбэр*” нь үйл үгтэй холбогдон түүнийг тодотгож өгдөг боловч энэхүү үүрэг нь үүсмэл тэмдэг нэрэнд бус, цэвэр тэмдэг нэрэнд ч бас байна. Хувилгах нөхцөл залгаж болохын хувьд тэмдэг нэртэй мөн адил байна. (*68-р тал*). Гэвч *-tai* нь ихэндээ нэр үг, тэмдэг нэрэнд залгаж болохын хувьд *-tsē*-ээс ялгаатай.

Дашрамд *-tsē-* нөхцөлийн утга нь өндрийч хэмжээ бус, хир хэмжээг заасан биш үү гэж бодож байна.

öwödögsē us

mörtsē us

-д өндрийн хэмжээг зааж байгаа боловч

tšaxĩtsē

xĩrxĩtsē - тэй харьцуулахад хир хэмжээг зааж байна гэж бодож байна.

Хувилгах нөхцөлийн утгын талаар (*утга зүйн талаас нь дурдах ёстой*) гэж тэмдэглэмээр байна. Би гадаад хэлний талаарх үзэл бодлоо энд холихгүй гэж ихэд чармайлаа.

Жишээ нь: Поппе профессорын өгөх оршихын тийн ялгал (*Dativ-Lokativ*)-ын нөхцөл *-da*-ийн утгыг (*үйл хөдлөл болж байгаа байрлал*) -ыг заасан гэхэд хангалттай биш үү. Тэрхүү үйл нь ямар нэгэн юм байгаа зүгийг чиглэх, ямар нэг юмны байрлалыг чиглэх гэсэн ийм ялгааг монгол хүн анзаардаггүй. Тэрхүү ялгаа нь энэ хэлбэртэй холбогдох үйл үгээр илэрнэ. Гэвч тэр үйл нь тэрхүү юманд нөлөөлсөн гэж үзэхгүй. (үйлийн нөлөөлөх объект) өөрөөр хэлбэл заахын тийн ялгал (*Akkusativ*)-ын нөхцөлөөр илэрнэ. Энэ мэт авсан олон жишээнээс үзэхэд монгол хэлний өгүүлбэрийн мөн чанарыг сайн мэдэх, гадаад хүн гэсэн байр сууринаас салж монгол хүний сэтгэл зүйг ойлгож байх шиг бодогдох тул дээрх утгыг зөв гэж бодном. Жишээ нь:

usanda jaowa

tsainda sū зэрэг өгүүлбэрийг дээрхтэй адил орчуулж болох боловч, монгол хэлээр эдгээр үйл нь (*ус*), (*цай*)-нд нөлөөлсөн бус, ус байгаа газар руу, цай байгаа газар руу чиглэн үйл хөдлөл явагдаж байгаа гэж үзэх нь зөв болов уу.

tūnig saidta songo

-ийн хувьд ч гэсэн (*сонгох*) гэдэг үйлийн нөлөөнд өртөж байгаа нь (*тэр хүн*) бөгөөд, (*цайд*) гэдэг албан тушаалд нөлөөлөөгүй. Гэвч (*сонгох*) гэх үйл нь (*цайд гэх байрлалийн хувьд*) биш (*цайд гэх албан тушаал руу чиглэх*) бөгөөд тэрхүү утга нь *said* болон *songo* гэсэн хэлбэр улмаар *saldta* болон *songo* гэдэг үгийн холбоогоор илэрч, *-ta* -нөхцөлөөр илрээгүй гэж бодож байна.

tšonondo idegde

(*чононд*) гэдэг үг нь (*идэгд*) гэсэн үйлийн байрлалыг илэрхийлж, зөвхөн байр, байрлал бус, үнэндээ (*чоно*) нь (*идэх*) гэсэн үйлийн эзэн болох бөгөөд, тэрхүү утга нь *tšono* болон *idegde* гэсэн хэлбэр улмаар *tšonondo*, *idegde* гэсэн үгийн холбоогоор илэрнэ гэж бодож байна.

mai sarĩṅ negende

гэсэн жишээ нь монгол хүний цаг хугацааны харилцааг ч үйл хөдлөл болж байгаа байрлалтай адилаар үзэж байгааг харуулж байгаа зүйл биш үү. Профессор нь *-da* нөхцөлийн утгын тухай дурдсан жишээгээ 8 ангилсан бөгөөд миний бие нэг л утгыг илэрхийлж байна гэж үзэж байгаа тул энэ нь хангалттай биш үү гэж бодно. Ингээд бодохлоор, энэхүү нөхцөлийн утга нь өгөх (*Dativ*) болон оршихын тийн ялгалын (*Lokativ*) махбодийг нэмж нийлүүлсэн биш, энэ хоёрт ялгаа байхгүй болохоор нь *Dativ-Lokativ* гэж нэрлэсэн нь тохиромжгүй мэт санагдана. Монгол хэлний хувилгах хэлбэрийг европ хэлний тийн ялгалын нэрээр нэрлэх нь миний хувьд тохиромжгүй боловч, хэрэв энэ нэрийг хэрэглэвээс зөвхөн *Dativ* гэж нэрлэвэл тохирох болов уу.

Dativ-ийн нөхцөлийн хувьд дээр дурдсанчлан зөвхөн нэг утгыг илэрхийлнэ гэж үзэх боломжтой боловч заавал тийм байна гэсэн үг бас биш юм.

Жишээ нь: гарахын тийн ялгал (*Ablativ*)-ын нөхцөл *-ās* утгын хувьд үйл үгтэй холбогдох тохиолдолд үйлийн эхлэх цэг гэж үзэж болох боловч тэмдэг нэртэй холбогдох тохиолдолд үүнээс өөр утга илэрхийлж байна. Алив нэгэн харьцуулсан зүйлээс бүр илүү гэсэн утгыг илэрхийлж байна гэж үзэх нь зүйтэй мэт бодогдоно. Хам цагийн үүднээс авч үзвэл ялгах утга бүхий хэлбэрийг дуудлага ижил, утга өөр хэлбэр

гэж үзэх ёстой. Гэвч энд маргаантай зүйл бол хоёр *-ās* гэсэн хэлбэр нь цуваа цагийн үүднээс үзэхэд нэг хэлбэрээс салж хуваагдсан болов уу.

Өөрөөр хэлбэл Instrumental нөхцөлийн хувьд:

utāgār

utānār

гэсэн ялгаа байна. Хам цагийн үүднээс авч үзвэл *-gār*, *-nār* нь утгын хувьд төдийгүй хэлбэрийн хувьд ч ялгаа бүхий хэлбэр гэж үзэх хэрэгтэй юм.

Дээр дурдсан зүйлд тодорхой байгаачлан нөхцөл өөрөөр хэлбэл ихэнхдээ хэлбэр түүний утга нь холбогдох үгийн утгаас ялгаатай байх ёстой. Профессор маань халх монгол хэлний нэрлэхийн тийн ялгал (*Nominativ*)-ын хэлбэрийг өгүүлэгдэхүүний тийн ялгал (*Subjektskasus*) гэж үзэхийн зэрэгцээ өгүүлэхүүний нэрийн тийн ялгал (*Kasus des Prädikatsnomens*) гэж үзэж дараах жишээг авсан байна. (104-р зүйл)

1. *mori beltšidži baina*

tsai butšaldži baina

2. *manai xū emtši bolso᠓*

1-р өгүүлбэрийн хэлбэр нь (*Снь P болох*) гэсэн утгыг илэрхийлж байгаа нь *mori* ба *beltšidži baina* гэсэн харьцаатай ба өөрөөр хэлбэл *tsai* болон *butšaldži baina* гэсэн харьцаатай байх, *mori* өөрөөр хэлбэл *tsai* гэсэн хэлбэрт (*Снь*) гэсэн утга байхгүй байна. Үүнтэй адил 2-р өгүүлбэрт *emtši bol-* гэсэн үгийн холбоо болох (*P болох*)-ийг илэрхийлэх утга нь *emtši* болон *bol-* гэсэн холбоо үг юм. *emtši* гэсэн хэлбэрт (*Р болох*) гэсэн утга байхгүй. Профессор (*Nominativ өөрөөр хэлбэл Subjektskasus нь Kasus des Prädikatsnomens¹*) гэж үзэж байгаа учраас одоохондоо ялгаа байхгүй гэж хэлж болох боловч зарим үед тохиолдох (*Nominativ хэлбэр нь 2 утгыг илэрхийлнэ*) гэсэнтэй санал нийлэхгүй байна. Ингэж үзвэл профессор Поппегийн *Nominativ*-аас өөр тийн ялгалын хэлбэрийг бий болгосон *Kasus indefinitus²* (*тодорхойгүй төлөөний үгийн буюу тийн ялгалын эс ялгах хэлбэр*)(113-р зүйл, 114-р зүйл)-нь *Nominativ*-тай адил “*тийн ялгалын хэлбэр*” гэж үзэх ёстой гэдэг нь тодорхой болох болов уу. “*Буриад монгол хэлэнд*” түүнтэй тохирох хэлбэр нь нэрлэхийн тийн ялгалын хэлбэрээс ялгаатай (жишээ нь: нэрлэхийн тийн ялгалын хэлбэр *uha᠓ (уc)* байгаа бол эс ялгах тийн ялгал (*uha*) нь халх монгол хэлний хувьд ч гэсэн энэхүү хоёр тийн ялгалын хэлбэрийг ялгах ёстой гэсэн үндэслэл болж чадахгүй юм. Гэхдээ халх монгол хэлний биеийн төлөөний нэрэнд *bi*, *tsī...* зэрэг “*нэрлэхийн тийн ялгалын хэлбэр*”-ээс гадна *nada*, *tšama...* гэх хэлбэр байх бөгөөд үүнтэй адил үүрэг бүхий нэр үгийн хувиллын хэлбэр нь “*нэрлэхийн тийн ялгалын хэлбэр*”-тэй хэлбэрээр адил байлаа ч өөр хувиллын хэлбэр гэж үзэх ёстой болов уу. Нөгөө талаар ямар нэгэн “*дагавар үгийн*” өмнө илрэх

širēn dēre

usan dotoro

зэрэг үгийн *širen*, *usan* гэх хэлбэр нь (*минийхээр бол авиалбар зүйн хувьд širē᠓, usa᠓ гэж галиглах ёстой болов уу гэж бодно*) *Nominativ*-ийн *širē*, *usa*-нь хэлбэрийн хувьд ч үүргийн хувьд ч ялгаатай учир өөр тийн ялгал гэж үзэх ёстой юм. Жишээ нь: биеийн төлөөний нэрэнд эдгээртэй адил үүрэгтэй хувилгах хэлбэр болгон *tūn dēre* гэдэг үгийн *tūn* (*зөв нь tū᠓*)-тэй адил хэлбэр профессорын хүснэгтэд байхгүй байна.

¹ *Kasus des Prädikatsnomens*-өгүүлэхүүний нэрийн ай

² *Kasus indefinitus*-а. Тодорхойгүй төлөөний үгийн ай б. Нэрийн тийн ялгалын эс ялгах ёс

Нэр үгийн үгийн үндэс болон хувилгах нөхцөлийн нийлэмжийн тухайд дүрмийн бус зүйл байгааг анхаарч тэмдэглэх нь чухал юм.

Харьяалахын тийн ялгал (*Genitiv*) (энэхүү нэр нь монгол хэлний хувилгах хэлбэртэй ул тохирох боловч)-ын нөхцөл залгаж дараахи байдлаар тэмдэглэсэн байна.

Үгийн үндсийн сүүлийн авиа дагавар

- (1) *n* -*i* (онцлон хэлэхэд *ai*)
- (2) бусад гийгүүлэгч, өөрөөр хэлбэл богино эгшиг -*īŋ*
- (3) *i* хос эгшиг өөрөөр хэлбэл *i* -*ŋ*
- (4) түүнээс бусад урт эгшиг -*gīŋ*

-*n*-ээр төгсөх үгийн үндэс нь тэрхүү -*n*-ийг үргэлж хадгалах, (-*ŋ*-тэй сэлгэх тохиолдол байлаа гэхэд) тэрхүү -*n*-нь тэгтэй сэлгэх гэсэн 2 зүйл байх (үүний тухай профессор 104-р зүйлд дурджээ.) Нөгөө талаар профессор нь -*ŋ*-ээр төгсөх үгийн үндэс болгон

dzusalāŋ *dzusalāŋgiŋ*

-*giŋ* гэсэн нөхцөл авснаас нь тодорхой байна. Энэ төрлийн үгийн үндэс - *ŋ* биш -*ŋg* -ээр төгсөх нь зөв юм.

Толь бичгүүдэд нэр үгийн хувиллыг дурдахдаа хам цагийн үүднээс зайлшгүй дурдах ёстой хэдэн хэдэн зүйл байна. 1. нэрлэхийн тийн ялгалын хэлбэр, 2. Энэ нь -*ŋg* -ээр төгсөх бол хувилах дагавар нь хамрын авиа нь -*n*-тэй сэлгэх үү, -*ŋg*-тэй сэлгэх үү, 3. эгшгээр төгсөх нэрлэхийн тийн ялгалын хэлбэр нь үгийн үндэс болон хувилахын хувьд - *ŋ* (-*n*-тэй сэлгэх) нэмэгдэх эсэх, 4. тэр нь нэмэгдэхгүй үгийн үндсийн дотор богино эгшгээр төгсөх бол *Dativ*-ийн нөхцөл -*da*-г авах уу, -*ta*-г авах уу, (жишээ нь: / *sara* / , / *sarada* / байгаа бол / *gara* /, / *garata* /) байна. Пр. Поппе нь тус номынхоо эцэст үгийн сангийн хувьд үүнтэй ойролцоо аргыг авсан бөгөөд 4-т дурдсан -*ta* авдаг үг нь гийгүүлэгчээр төгсдөг хэмээжээ.

Төлөөний нэрийн дотор биеийн төлөөний нэр нь дараах байдалтай байна.

Ганц тоо	олон тоо
1-р бие <i>bi</i>	<i>bide</i>
2-р бие <i>tši</i>	<i>tā</i>

Гэвч төлөөний нэрийн ганц тоо нь *bī*, *tši*- гэж авиа нь урт байна. Өмнө нь *tā* нь *ta* болж байсан учраас эдгээр төлөөний нэрийн харьяалахын тийн ялгалын хэлбэр нь

Mini (миний) *tsini* (чиний) *tani* (таны) -тай адил аль аль нь нэгдүгээр үед богино эгшигтэй тул хэлбэрийн талаас нь авч үзвэл нэрлэхийн тийн ялгал *bi*, *tši*, *ta* гэж эгшгийг богиноор галиглах болов уу гэж бодож байсан. Гэвч хоёрдугаар биеийн олон тооны хэлбэрийг *tā* гэж галигласан бол ганц тооны хэлбэрийг ч гэсэн *bī*, *tši* гэж галиглах ёстой болов уу. *xi* (хий, 氣體) гэх үгийг ингэж галигласан байх бөгөөд эгшгийн урт нь *xī*, *bī*, *tši* -гэхэд ялгаагүй юм.

Дашрамд *tani*-ийг *tanaī*-тай сэлгэсэн хэлбэр болгон тэмдэглэсэн байх боловч миний мэдэхээр өмнөх нь (таны), дараахи нь (таны, танайх, танай улсын) гэх ялгаатай байна. Өмнөх нь *mini*-тэй адил, дараах нь *tanaī*-тай адил байна.

Мөн энэ мэтийн нарийн зүйл бичээд байвал дуусахгүй тул 72-р тал дахь (*ene*, *tere*)-ийн хувилгах хэлбэрийн хүснэгтэд хэлбэр нь байхгүй доогуур зурсан зураасын оронд *enī*, *terende*, *ternīg*, *terentē* гэж нөхөж болно.

Үйл үгийн хувиллын тухайд өмнө нь бичсэн өгүүлэлд нэлээд тодорхой дурдсан тул энд хэдхэн зүйлийн тухай дурдъяа.

78-р талд (*Voluntativ*)³-ийн нөхцөл болгон *-jā, (-jē, -jō, -ju)* oder *-jī* auch *-ī* und *-īi* гэж тэмдэглэж *jawajā~jawajī~jawī~jawajī* зэрэг жишээ авсан байна. Онцолж хэлэх үед [*jaβaja:*] гэсэн дуудлага сонсогдох боловч энгийн хэлэх үед [*iji*]-тай адил хэлнэ. Суларсан авиагаар энэхүү [*iji*] нь бараг [*i:*]-тэй ойролцоо хэлэгдэх бөгөөд [*i*]-нь суларсан эр эгшиг [*Λ*] нь [*i*]-тэй ижилшсэн гэж үзэж болох учраас [*jaβiji*] нь авиалбар зүйн */jabaja/* гэж тайлбарлах ёстой гэж болов уу гэж бодож байсан боловч кирилл үсгийн зөв бичгийн дүрэмд ЯВЪЯ гэж бичдэгийг мэдэж авсан юм. (*А.Р. Ринчинэ (1947) Краткий монгольско-русский словарь. Москва.*). Дашрамд хэлэхэд, миний бие Улаанбаатарт байнга оршин сууж ажиглалт хийгээгүй тул тус аялгуунд */ii/* гэсэн нөхцөл огт байхгүй гэдгийг баталж чадахгүй юм. Цахар аялгуунд */abaii/, /idii/, /bicii/* гэсэн хэлбэрүүд байдгийг “*Хэл шинжлэл*” 19/20-рм дурдсан юм.

Мөн пр. Поппе нь дээрх *Voluntativ* -ын хэлбэрийн утгыг (*би болон бидний тухай дурдагдах газар үйлийг хийх хүсэл, үйлдлээ хэрэгжүүлэхийг ятгах, энэхүү хэлбэр нь нэгдүгээр биеийн ганц тоо болон олон тоотой холбоотой юм. Хориглох туслах үг⁴ бь-тэй хамт илэрнэ*) хэлмээн тэмдэглэсэн байна. Хэрвээ би үүний тухай дурдвал энэхүү нөхцлийн утга нь (*яригч этгээд нь алив үйл хийхийг хүсэх*) гэж үзэж болох бөгөөд тэрхүү үйлийг яригч этгээд ганцаараа хийх үү, эсвэл өөр хүнтэй хамт хийх үү гэдэг нь *bī, bida* зэрэг хэлбэр, болон тухай үеийн байдлаар илрэх юм. Хориглох туслах үг *бь* биш *bī* юм.

Өөрөөр хэлбэл нөхцөл үйл үгийн⁵ (*Konverba*) 23 зүйлийн тухайд хэдэн үг хэлмээр байна. Төгсөөгүй нөхцөл үйл үг (*Konverbum imperfecti*) ялангуяа, нөхцөл *-dži-* залгаж хувилгасан хэлбэрийн утгыг профессор дараах байдлаар дурдсан байна. (*Тайлбарын хувьд өөрчлөх хязгаар болгон бусад үйл хөдлөлтэй хамсах, аливаа үйл хөдлөл, хоёр үйл үг нь түүний нөлөөгөөр нэг дан үгийн хэлбэртэй болох, заримдаа зөвхөн ганцхан гэх ойлголтыг илэрхийлэх, европын хэлний нийлмэл үйл үгтэй тохирч байна.*)

Төгссөн нөхцөл үйл үг (*Konverbum perfecti*) *-ād-* залгаж хувилгасан хэлбэрийн утга нь (*гол үйл хөдлөл нь цаг хугацааны хувьд түрүүлэх алив үйл, иймээс энэхүү хэлбэрийг учир шалтгааны холбоотой утгыг илэрхийлэх үед ч хэрэглэнэ.*) “*Төгсөөгүй нөхцөл үйл үг*”-тэй жишээнээс үзэхэд аль аль нь ардаа өөр үйл үг дагуулсан жишээг голдуу авсан байх бөгөөд хоёр үйл үгийн хооронд урт үгс холбогдож (*энэ нь дараагийн үйл үгтэй холбогдох*) жишээ цөөнгүй байна. Миний хувьд *-dži-* нөхцөл нь нь (*алив үйл хөдлөлтэй зэрэгцэж*) (*өөр үйл хөдлөл байх*) гэсэн утгатай гэж үзэж байна. Мэдээж бодит байдалд хоёр үйл хөдлөл нэгэн зэрэг болох албагүй боловч монголчууд энэхүү “*төгсөөгүй нөхцөл үйл үг*”-ийг хэрэглэх үед энэхүү хоёр үйл нэгэн зэрэг болно гэж үзэж байгааг авсан олон жишээнээс мэдэж болох учраас ингэж үзэх нь зөв гэж бодогдож байна. Мөн монгол хэлний “*Төгсөөгүй нөхцөл үйл*” + үйл үг гэсэн хэлбэрээр илрэх үйл хөдлөл нь бусад хэлний талаас авч үзвэл нэг үйл гэж үзэж болох боловч монголчууд нь нэгэн зэрэг болох хоёр үйл гэж үздэг бөгөөд тэгэж үзэх ёстой гэж бодож байна.

Монгол хэлний *nistši ir-* гэдгийг орос хэлний прилететь-тай харьцуулж үзье.

³ *Voluntativ*-үйлийн 1-р биеийн шийдэн хүсэх хэлбэр (-я, е, ё)

⁴ хориглох туслах үг гэдэг нь хориглох утга бүхий сул баймжит бүтээвэр юм.

⁵ нөхцөл үйл үг (төгсөөгүй нөхцөл үйл үг, төгссөн нөхцөл үйл) нь одооны үйлийн тийн ялгалын нөхцөл болно.

"Төгссөн нөхцөл үйл үг" нөхцөл *-dži*-ийн хувьд минийхээр бол (*алив үйл хөдлөл төгссөний дараа үргэлжлээд өөр үйл хөдлөл болох*) гэсэн утгатай гэж үзэж байна. Энэхүү (*үргэлжлээд*) гэсэн зүйл нь чухал бөгөөд алив үйл хөдлөл нь нь өөр бусад үйл хөдлөлөөс цаг хугацааны хувьд түрүүлж байна гэж үзвэл өөр хэлбэрээр илэрхийлэх (*жишээ нь: -saṅ xoīno*) *morimin etsēd üxelē* -ийг *mein Pferd infolge Überanstrengung* гэж орчуулбал алдаа гарахгүй боловч монгол өгүүлбэрт (*миний морь эцээд (үргэлжлээд үхлээ)*) гэж илэрхийлсэн байх бөгөөд үүнд хэд хэдэн учир шалтгааны холбоо (*энэ нь яг бодитой оршиж байгаа нь өөр асуудал байлаа ч*) илрэхгүй байна гэж бодож байна. Ингээд бодохоор,

- *dži baina*

- *ād baina*

- *saṅ baina*

хэлбэрт утгын ялгаа байгаа нь тодорхой байна. Нөхцөл *-saṅ*-ийн утгын тухай Хэл судлал сэтгүүлийн 22/23 дугаар, 382 хуудаснаас үзнэ үү

Жишээ нь: *Xebtedži baina* гэсэн өгүүлбэр нь ярьж эхэлсэн хэдхэн агшны дараа (унтах, хажуулдах) гэсэн үйл хөдлөл үргэлжлээд өрнөж байна гэдгийг илэрхийлж байна. "*Xebtēd baina*" гэх өгүүлбэр нь үйл хөдлөл төгсөж (*дараа нь*) тэр байдал хэвээрээ үргэлжлэхийг зааж байна. *Xebtesēṅ baina* гэх өгүүлбэр нь тэрхүү үйл нэгэнт өнгөрөн төгсөж түүний үр дүнд одоогийн байдалд байна гэсэн илэрхийлэл юм. Өөрөөр хэлбэл жишээ нь: нэгэнт орондоо орсныг илэрхийлж байгаа боловч ярих агшинд түр босоод явсан байлаа ч энэ хэллэгийн хувьд асуудал болохгүй юм. Тэгвэл *Xebtēd baina* гэдэг нь одоо орондоо хэвтэж байна гэдгийг илэрхийлнэ. (*Тэр агшинд түр босоод явсан гэж үзвэл энэ өгүүлбэрийг ярьсан этгээд буруу бодсон, түүнийгээ мэдсээр байж энэ өгүүлбэрийг ярьсан гэж үзвэл тэрхүү яригч этгээд худлаа ярьсан болж таарна*). Эдгээр нь (*ярианы утгатай*) холбоотой болохоос (*өгүүлбэрийн утгатай*) холбоогүй юм. (*Үүний тухай Хэл судлал сэтгүүлийн 22/23 дугаараас үзэх*).

Сүүлийн бүлэг дэх Өгүүлбэр зүй нь (*ерөнхий хэсэг, өгүүлбэрийн бүрэлдэхүүн, холбох үг, өгүүлбэр бүтээх*) зэргээс бүрдэж байна. 16-р нүүрт нэлээд тодорхой бичсэн байгаа бөгөөд түүнийг уншихад монгол хэлний өгүүлбэр нь ямархуу бүтэцтэй байдгийг ойлгож мэднэ. Гэвч товчоолох аргын тухайд миний хувийн бодол байдаг бөгөөд энд жишээ авч хэдэн зүйлийн тухай дурдъяа.

205-р зүйлд профессор дараах зүйлийг дурджээ. Монгол хэлэнд өгүүлэгдэхүүн нь ямагт өгүүлэхүүндээ захирагдаж байх тул өгүүлбэрт хэний тухай өгүүлж байна вэ гэдгийг ойлгоход өгүүлэгдэхүүний хувьд тусгай хэллэг байхгүй ч байж болно. Жишээ нь: *textlēr asūdži "darauf frage"* (*d.h.er,der schon erwδhnte*) гэхчлэн өгүүлэгдэхүүнгүй өгүүлбэр их хэрэглэгддэг юм. Гэвч монгол хэлний өгүүлбэрийн "өгүүлэхүүн"-нд (*өгүүлэгдэхүүн нь захирагдах*) (*das Subjekt inhdriert*) гэдэг нь эргэлзээтэй юм. Халх монгол хэлэнд "өгүүлэхүүн" гэж хэлэгдэх хэлбэрийн утгад "өгүүлэгдэхүүнийг" илэрхийлэх махбодь байдаггүй, иймээс "өгүүлэгдэхүүнгүй өгүүлбэрийн" илэрхийлэх утгад "өгүүлэгдэхүүн" багтдаггүй гэж үзэх ёстой болов уу. Энэхүү номонд орсон "өгүүлэгдэхүүнгүй" өгүүлбэрийн байдлаас харахад "өгүүлэгдэхүүн" нь тодорхой байх тохиолдолд л зөвхөн хэрэглэнэ гэсэн үг биш учраас халх монголчууд нь япон хүнтэй нэгэн адил үйлийн эзнийг илэрхийлэх биш зөвхөн үйл хөдлөлийг илэрхийлэх онцлогтой байгаа юм биш үү?

Үүнээс гадна өгүүлэхүүн болон тусагдахууны тухайд ч гэсэн баруун европын хэлний үзэл бодлоор тайлбарлах нь эрсдэлтэй биш үү гэж бодогдох зүйл байна.

220-р зүйлд *xoinoson otšiq geseŋ⁶ xānī gurwan xīxex džimis tūdži jawadži baisaŋ* гэсэн өгүүлбэрт *geseŋ* гэх гурван үгээс бүтэх үгийн үргэлжлэл “өгүүлэгдэхүүн” гэж тайлбарлаж байгаа боловч энэ *geseŋ* гэдэг үг нь “үйлт нэр” байж нөхцөл үйл үгийн хэлбэрээр хэрэглэгдсэн учраас ийм үед заавал өндөрсгөсөн аялгаар хэлдэг. Энэ нь халх аялгууны хувьд өргөн хэрэглэгдэх арга юм.

Эцэст нь жишээ өгүүлбэрүүдийн талаар хэдэн үг хэлье. Жишээ өгүүлбэрт -*tšin* гэсэн хэлбэр байна. (145-р талын 25, 26, 31, 38-р мөр) үүнд түүний залгах хэлбэрийн утгад анхаарлаа хандуулж, үүнийг онцолж хэлэх үүрэг бүхий хэлбэр тул цуваа цагийн үүднээс -*tši* болон -*n* гэж задлах ёстой биш, чиний гэсэн утгатай -*tšin*-ч (§95, §123) бас биш учраас тусгайлан дурдах ёстой байсан юм.

146-р талын 13,17-р мөрд *ōnōdūlītšin* гэсэн хэлбэр байна. Үгийн сангийн 182-р талд *ūnōdūl* нь *ūnū* -ийн олон тооны хэлбэр учраас дээрх хэлбэр нь *ōnōdūlītšin* гэж нийлүүлэн галиглах ёстой юм. Дашрамд *ene* болон *ōnō*-ийг хамтад нь “*dieser*” гэж орчуулж байгаа боловч монгол хэлэнд энэ хоёр үгийн утга нь ялгаатай юм. “*ene, ter*” нь орон зайн хувьд объектыг заах үед хэрэглэж, *ōnō*-г тэрхүү газар байхгүй ч ярианд жишээ болгон авсан объектыг буцаан заах үед хэрэглэдэг. Япон хэлний (この, その) “энэ, тэр” гэдэг үгийн хувьд ийм ялгаа байхгүй юм.

Эцэст нь тэмдэглэхэд, нэлээд олон асуудлын тухай өгүүллээ. Поппе профессор хэлний товчоолох аргын тухай олон шинэ саналыг дэвшүүлэн тавьсныг уншигчид ч гэсэн анзаарах болов уу. Иймд миний дурдсан зүйлүүд цөм зөв байлаа ч энэхүү номын үнэ цэнийг бууруулахгүй гэдэгт итгэж байна. Учир юунд хэмээвээс миний бичихээр төлөвлөж байсан товчоолох аргаар бичигдсэн хэлний зүйн номыг би урьд өмнө харж байгаагүй юм. Тиймд миний бие дээр нэлээд нээлттэй өөрийнхөө санааг дурдсаныг ч Поппе профессор маань уучлах болов уу.

Дорно дахины судалгааны нийгэмлэгийн Мотода нөхрийн хүсэлтээр чадан ядан ийм өгүүллийг бичлээ. Цаг тун хомс байлаа. Энэхүү танилцуулах шүүмж маань миний санаанд үл хүрсэн төдийгүй өөрийнхөө хэлмээр байсан зүйлийг бүрэн гүйцэд гаргаж чадсангүй. Ингээд Мотода нөхрийн хүсэлт байгаагүй сан бол энэ хирийн өгүүлэл бичиж чадахгүй байсан болов уу хэмээн бодон талархлаа илэрхийлье.

1953 оны 7 сарын 26-ны өдөр

服部四郎著『言語学の方法』(岩波書店) номын 582-596-р тал

⁶ “*gesentšīn, gesentšī*”-гэж биеийн хамаатуулах нөхцөл, зэрэгцүүлэн онцлох нөхцөл оруулбал сая үйлт нэр нь үйлийн тийн ялгалын үүрэгтэй болох нь тодорхой болно. (орчуулагч)